

АШУУИС-ИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГУУЛИЙН ЭЛСЭЛТ АВАХ МЭРГЭЖИЛ /БАКАЛАВР/

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД СУДЛАЛЧ

Нийгмийн эрүүл мэнд судлалч нь хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулдаг.

ХӨРВӨХ ЧАДВАР, ДАВУУ ТАЛ

- Хүүхдийн эрүүл ахуйч
- Тархвар судлалч, биостатистикч
- Орчны эрүүл ахуйч
- Хүнсний эрүүл ахуйч
- Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч /хүнс, хөдөлмөр, хүүхдийн эрүүл ахуйн чиглэлээр/
- Халдвар судлаач
- Уул уурхай, аж ахуйн нэгжүүдэд эрүүл ахуйч

ТӨГСӨӨД ХААНА АЖИЛЛАХ ВЭ?

- Салбарын яам, Их, дээд сургууль, судалгааны байгууллага
- Аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
- Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд
- Салбарын яам, Үйлдвэр, ААН байгууллага
- Олон улсын байгууллагууд

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙЧ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭРГЭЖИЛТЭН

Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын чиглэлээр оюутан төвтэй, чадамжид суурилсан сургалтаар хөдөлмөр эрхлэгчийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг үүсгэх хүчин зүйлсэд хяналт тавих, илрүүлэх, эрсдлийг бууруулах замаар ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах мэдлэг, хандлага, чадвартай мэргэжилтэн юм.

ХӨРВӨХ ЧАДВАР, ДАВУУ ТАЛ

- Судлаач мэргэжилтэн
- хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
- НЭМ-ийн мэргэжилтэн, судлаач
- Олон улсын байгууллагуудад нийгмийн эрүүл мэнд судлаач
- Эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч

ТӨГСӨӨД ХААНА АЖИЛЛАХ ВЭ?

- Томоохон үйлдвэр, уул уурхайн аж ахуйн нэгж байгууллага
- Салбарын яам, их дээд сургууль
- Олон улсын болон лавлагаа тусламж судалгааны байгууллага

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭДИЙН ЗАСАГЧ

Хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай хүргэхэд шаардлагатай нөөцийн хуваарилалт, байгууллагын үйл ажиллагааны үр өгөөжийг оновчтой хийхэд шаардлагатай нотолгоог бүрдүүлэх, салбарын үйл ажиллагааг үнэлэх, судлах чадвартай мэргэжилтэн болно.

ХӨРВӨХ ЧАДВАР, ДАВУУ ТАЛ

- Эрүүл мэндийн эдийн засагч
- Статистикч эмч
- Нягтлан бодогч, нярав
- Хүний нөөцийн мэргэжилтэн
- Хяналт-шинжилгээний мэргэжилтэн
- Стратеги төлөвлөгөөний мэргэжилтэн
- Дотоод аудитор

ТӨГСӨӨД ХААНА АЖИЛЛАХ ВЭ?

- Эм ханган нийлүүлэх байгууллага
- Эмийн үйлдвэр
- Банк, санхүүгийн байгууллага
- Олон улсын байгууллага
- Захиргааны нэгжүүд
- Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд
- Төрөлжсөн болон лавлагаа тусламж үйлчилгээний төвүүд

ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН

Хүн амын нийгэм-сэтгэл зүйн асуудал, хэрэгцээг үнэлэх, тэдний нөөц боломжийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, хамгаалах зорилгоор нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг. Мөн хүүхэд хамгаалал, ахмад настан, гэр бүлийн чиглэлээр кейс менежер, олон нийтийн асуудлыг судлах, таниулан нөлөөлөгч, олон мэргэжлийн баг зохион байгуулагч хамтран ажиллагч, нийгмийн эрүүл мэнд, сэтгэлзүй, харилцааны асуудлыг судлах судлаач, эрүүл мэндийн боловсрол олгогч, эрүүл мэндийн зан үйл өөрчлөх, зөвлөх чадвартай мэргэжилтэн юм.

ХӨРВӨХ ЧАДВАР, ДАВУУ ТАЛ

- Эрүүл мэндийн нийгмийн ажилтан
- Чанарын албаны мэргэжилтэн, судлаач,
- Нөхөн сэргээх, сэтгэлзүйн тасгийн мэргэжилтэн
- Өвчтөн дэмжих, нэг цэгийн үйлчилгээний нийгмийн ажилтан
- Кэйс менежер
- Эрүүл мэнд, нийгмийн асуудлыг судлах мэргэшсэн судлаач

ТӨГСӨӨД ХААНА АЖИЛЛАХ ВЭ?

- Дүүргийн эрүүл мэндийн төв
- Гуравдугаар шатлалын эмнэлгүүдэд
- Эрүүл мэндийн төрийн бүс байгууллагуудад
- Дунд сургуулиудад
- Судалгаа, олон улсын байгууллага

ШИМ ТЭЖЭЭЛ СУДЛАЛЧ, ХООЛ ЗҮЙЧ

Хүн амыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, эрүүл мэндийг дэмжихэд хоол хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн ач холбогдол, хүнснээс шалтгаалах өвчний эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг олон улсын жишигт нийцсэн хүнлэг энэрэнгүй, ёс зүйтэй тусламж үйлчилгээ хүргэх цогц чадамжтай мэргэжилтэн байна.

ХӨРВӨХ ЧАДВАР, ДАВУУ ТАЛ

- Шим тэжээл судлалч-Хоол зүйч
- Ерөнхий хоол зүйч
- Хувийн дасгалжуулагч-Хоол зүйн чиглэлээр
- Нийгмийн эрүүл мэнд судлалч
- Клиникийн хоол зүйч
- Ерөнхий боловсролын сургуулийн хоол зүйч

ТӨГСӨӨД ХААНА АЖИЛЛАХ ВЭ?

- Улсын II-III шатлалын эмнэлгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар
- Аймгуудын бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд
- Тусгай мэргэжлийн төвүүд
- Хувийн ортой, хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар
- ЕБСургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар
- Зэрэглэлтэй зочид буудал
- Хоол үйлдвэрлэлийн байгууллага

БАКАЛАВРЫН ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ

Элсүүлэх мэргэжил	Суралцах хугацаа	Өгөх ерөнхий шалгалт
Нийгмийн эрүүл мэнд судлалч	5 жил	Хими Биологи
Эрүүл мэндийн нийгмийн ажилтан	4 жил	Биологи Нийгмийн тухай мэдлэг
Хөдөлмөрийн эрүүл ахуйч аюулгүй байдлын мэргэжилтэн	4 жил	Хими Физик
Шим тэжээл судлалч, хоол зүйч	4 жил	Хими Биологи
Эрүүл мэндийн эдийн засагч	4 жил	Математик Физик

*Бүх мэргэжлээр Монгол хэлний шалгалт өгөх ба босго оноо 400-с дээш байх шаардлагатай. АШУУИС-д Улаанбаатар хотоос элсэгчдийг <http://burtgel.mnnums.edu.mn> цахим бүртгэлийн системээр бүртгэнэ.

ЯАГААД НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГУУЛИЙГ СОНГОХ ЁСТОЙ ВЭ ?

- ✓ **БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН:** Эрдмийн, мэргэжлийн цол зэрэгтэй үндэсний хэмжээнд тэргүүлэх эрдэмтэд, судлаачдаас бүрдсэн мэргэжлийн өндөр үр чадвартай багшлах бүрэлдэхүүнтэй.
- ✓ **60 ЖИЛИЙН ТУРШЛАГА:** Нийгмийн эрүүл мэндийн салбарын мэргэжилтэн 1956 оноос бэлтгэж эхэлсэн туршлагатай.

- ✓ **МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨТӨЛБӨРҮҮД:** Олон улсын болон үндэсний түвшинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрүүдтэй.
- ✓ **Тухайн чиглэлээр мэргэшсэн, үндэсний хэмжээнд ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН** байгууллагуудад **ГЭРЭЭТ ДАДЛАГА** хийдэг.
- ✓ **АЖЛЫН БАЙРАН ДАХЬ СУРГАЛТЫН ДАВУУ ТАЛ:** дадлагыг хөдөө орон нутаг, мэргэжлийн сургалтын лаборатори, судалгааны төвд хийдэг онцлогтой.
- ✓ **ЧӨЛӨӨТ ЦАГ:** оюутны суралцах орчин нөхцөл бүрдсэн, хоол, спорт, амрах орчинтой.

- ✓ **ОНЛАЙНААР ХӨТӨЛБӨР:** сонгон суралцах хичээлүүдийг <http://elearning.mnnums.edu.mn/> системээр шууд судлах боломжтой.
- ✓ **Улсын хэмжээнд ХАМГИЙН ТОХИЛОГ, ШИНЭЛЭГ ОЮУТНЫ ДОТУУР БАЙРТАЙ**
- ✓ **АЛТАН ГАГНУУР:** жил бүр төсөгчидтэй уулзалт зохион байгуулдаг, хамгийн том мэргэжлийн сүлжээтэй.
- ✓ **МОНГОЛ –ЯПОН СУРГАЛТЫН ЭМНЭЛЭГ: ХАМГИЙН СУУЛИЙН ҮЕИЙН** Их сургуулийн эмнэлэгтэй
- ✓ **ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ОЛОН ТӨРЛИЙН** хөтөлбөрүүдтэй, боловсролын зээлийн санд хамрагдах боломжтой,
- ✓ **НОМЫН САН:** цахим номын сантай, 150.000 гаруй номтой, бүх төрлийн заалтай, хамгийн том, тохилог орчинтой.
- ✓ **ОЮУТАН СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨРТЭЙ:** ОХУ, БНСУ, Японы сургуулиудтай хамтарсан хөтөлбөрүүдтэй.
- ✓ Төгсөгчдийн **90 ХУВЬ НЬ МЭРГЭЖЛЭЭРЭЭ АЖИЛЛАДАГ.**